



ХОВД АЙМАГ ДАХЬ ЗАХИРГААНЫ  
ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН  
ШҮҮГЧИЙН ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 16 өдөр

Дугаар 125/ШЗ2024/0231

Жаргалант сум

ЗАХИРГААНЫ АКТЫН БИЕЛЭЛТИЙГ  
ТҮДГЭЛЗҮҮЛЭХ ТУХАЙ

Ховд аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг шүүгч М.Мянганбаяр би даргалж,

Нэхэмжлэгч: "Турлиахт" ХХК-нийн нэхэмжлэлтэй,

Хариуцагч: Ховд аймгийн Худалдан авах ажиллагааны газар, Тендерийн үнэлгээний хороонд холбогдох,

Нэхэмжлэлийн шаардлага: "Ховд аймгийн Худалдан авах ажиллагааны газраас зарласан ЭМЯ/20240101018 дугаартай "Эрүүл мэндийн төвийн барилга" (Ховд, Цэцэг сум) ажлын тендерт нэхэмжлэгч "Турлиахт" ХХК-ийн тендерийг шаардлагад нийцээгүй тендер гэж үнэлсэн Үнэлгээний хорооны шийдвэрийг хүчингүй болгуулах, Ховд аймгийн Худалдан авах ажиллагааны газраас зарласан ЭМЯ/20240101018 дугаартай "Эрүүл мэндийн төвийн барилга" (Ховд, Цэцэг сум) ажлын тендерт нэхэмжлэгч "Турлиахт" ХХК-ийг шалгарсанд тооцож гэрээ байгуулахыг даалгах"-ыг хүссэн нэхэмжлэлтэй захиргааны хэрэгт нэхэмжлэгчийн "Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх тухай" хүсэлтийг хянан хэлэлцэв.

Урьдчилсан хэлэлцүүлэгт: Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Л.Мөнхбаяр, хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Ц.Энхтайван, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга Р.Лхагвасүрэн нар оролцов.

ТОДОРХОЙЛОХ нь:

Нэхэмжлэгч "Турлиахт" ХХК-ийн захирал Д.Лхамсүрэн шүүхэд гаргасан хүсэлтдээ: Манай компани Ховд аймгийн Худалдан авах ажиллагааны газар болон тухайн газраас байгуулсан үнэлгээний хороонд холбогдуулан "Ховд аймгийн Худалдан авах ажиллагааны газраас зарласан ЭМЯ/20240101018 дугаартай "Эрүүл мэндийн төвийн барилга" (Ховд, Цэцэг сум) ажлын тендерт нэхэмжлэгч "Турлиахт" ХХК-ийн тендерийг шаардлагад нийцээгүй тендер гэж үнэлсэн Үнэлгээний хорооны шийдвэрийг хүчингүй болгуулах, Ховд аймгийн Худалдан авах ажиллагааны газраас зарласан ЭМЯ/20240101018 дугаартай "Эрүүл мэндийн төвийн барилга" (Ховд, Цэцэг сум) ажлын тендерт нэхэмжлэгч "Турлиахт" ХХК-ийг шалгарсанд тооцож гэрээ байгуулахыг даалгах"-аар нэхэмжлэл гаргасан. Энэ хугацаанд ЭМЯ/20240101018 дугаартай "Эрүүл мэндийн төвийн барилга" (Ховд, Цэцэг сум) ажлын тендерийг дахин зарлаж болзошгүй байгаа тул хэрэг хянан шийдвэрлэгдэж дуусах хүртэл хугацаагаар уг тендер шалгаруулалтыг түдгэлзүүлж өгнө үү гэжээ.

Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Л.Мөнхбаяр урьдчилсан хэлэлцүүлэгт тайлбарлахдаа: Манай компани нь Ховд аймгийн Цэцэг сумын Эрүүл мэндийн барилгын төслийн тендер шалгаруулалтад оролцсон. Тус тендерт манай компани болон өөр нэг компани оролцсон ба тус тендер шалгаруулалтын шаардлагад нийцээгүй гэсэн мэдэгдлийг хүлээн авсан. Тус мэдэгдлийг хүлээн авч Сангийн яаманд гомдол гаргасан. Манай зүгээс тендер шалгаруулалтад оролцоод уг тендер шалгаруулалт хуулийн дагуу явагдаагүй гэж үзсэн учраас шүүхэд нэхэмжлэл гаргасан. Шүүхийн процесс үргэлжилж

байх хугацаанд тус тендер шалгаруулалт дахин зарлаж өөр компаниуд оролцоод шалгарах боломжтой байгаа учраас уг маргаан анхан шатны шүүхээр шийдвэрлэх хүртэл уг тендерийг дахин зарласан тендерийн үнэлгээний хорооны шийдвэрийн биелэлтийг түдгэлзүүлж өгнө үү гэв.

Хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Ц.Энхтайван урьдчилсан хэлэлцүүлэгт тайлбарлахдаа: Уг тендер шалгаруулалтыг дахин зарлаж, 2024 оны 8 дугаар сарын 06-ны өдрөөс 2024 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн 09:00 цаг хүртэл тендерийн материалыг нээлттэй хүлээн авч байгаа. Нэхэмжлэгчийн зүгээс гаргасан захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх хүсэлтийг дэмжиж байна гэв.

#### ҮНДЭСЛЭХ нь:

Нэхэмжлэгч "Турлиахт ХХК"-иас ЭМЯ/20240101018 дугаартай "Эрүүл мэндийн төвийн барилга" (Ховд, Цэцэг сум) ажлын тендерийн дахин зарласан тендерийн үнэлгээний хорооны шийдвэрийн биелэлтийг түдгэлзүүлэх хүсэл гаргасан ба хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс уг хүсэлтийг дэмжиж байгаа талаар урьдчилсан хэлэлцүүлэгт тайлбарласан.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1-д "Энэ хуулийн 62 дугаар зүйл, эсхүл хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд шүүгч хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтээр захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлнэ" гэж заасан ба мөн хуулийн 62 дугаар зүйлийн 62.1-д Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлж болохгүй тохиолдлуудыг нэрлэн заасан.

Хариуцагчаас хариу тайлбарын хамт ирүүлсэн баримтаас үзвэл тендерийн үнэлгээний хорооны 2024 оны 8 дугаар сарын 06-ны өдрийн 02 дугаар хуралдааны тэмдэглэлд ЭМЯ/20240101018 дугаартай "Эрүүл мэндийн төвийн барилга" (Ховд, Цэцэг сум) ажлын тендерийг дахин зарлахаар шийдвэрлэжээ.

Гэвч Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлж болохгүй үндэслэл, түүнд хамаарах баримтуудыг хариуцагчаас ирүүлээгүй, хэрэгт авагдсан баримтаар Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 62 дугаар зүйлд заасан захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлж болохгүй нөхцөл байдал тогтоогдоогүй тул нэхэмжлэгчийн захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх тухай хүсэлтийг хангах нь зүйтэй гэж үзлээ.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.1, 111.2 дахь хэсэгт заасныг удирдлага болгон ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1 дэх хэсэгт заасныг баримтлан "Турлиахт" ХХК-нийн нэхэмжлэлтэй, Ховд аймгийн Худалдан авах ажиллагааны газар, Тендерийн үнэлгээний хороонд холбогдох захиргааны хэрэгт ЭМЯ/20240101018 дугаартай "Эрүүл мэндийн төвийн барилга" (Ховд, Цэцэг сум) ажлын тендерийг дахин зарласан тендерийн үнэлгээний хорооны шийдвэрийн биелэлтийг 2024 оны 8 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн уг хэргийг эцэслэн шийдвэрлэх хүртэл хугацаагаар түдгэлзүүлсүгэй.

2. Шүүгчийн захирамжийг хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч нарт мэдэгдэхийг шүүгчийн туслахад даалгасугай.

3. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.1-т заасны дагуу хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч нь энэхүү шүүгчийн захирамжид бичгээр гарсан өдрөөс нь хойш 7 хоногийн дотор Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй.

ДАРГАЛАГЧ, ШҮҮГЧ



М.МЯНГАНБАЯР